



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/98

Сүхбаатар сум

Хөрөнгө оруулалтын ажлыг сайжруулах, ажил хариуцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "б", 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.7 14.2.8, 65 дугаар зүйлийн 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.3, Сангийн сайдын 2012 оны 290 тоот тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам", Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам", Сангийн сайдын 2017 оны 363 тоот тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сан, замын сангийн хөрөнгө оруулалтаар батлагдсан ажил, төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог байгуулах, тоног төхөөрөмж хүлээн авах ажлын хэсгийг байгуулах, тендерт шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах ажлуудыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ө.Сувдаа/-д, Хөрөнгө оруулалтын ажлын техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг баталгаажуулж тендерт шалгарсан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангуулж, гүйцэтгэлийг хянан батлах, санхүүжүүлэх, ашиглалтад оруулах улсын комиссыг удирдлага, зохион байгуулалтаар хангах, мөн дараа оны хөрөнгө оруулалтыг төлөвлөх ажлуудыг аймгийн Засаг даргын орлогч /Ж.Сайнцог/-д тус тус даалгасгай.

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан аймагт хэрэгжих ажлын захиалагчийн хяналтыг аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга /Б.Саруултөгс/-д, аймаг, сумдын орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, замын сангийн хөрөнгө оруулалтын ажлуудын захиалагчийн хяналтыг "Сэлэнгэ барилга захиалагч" ОНӨААТҮГ-ын дарга /Б.Мөнхбат/-д тус тус хариуцуулж, хөрөнгө оруулалтын ажлыг гэрээт хугацаанд батлагдсан зураг төсвийн дагуу чанартай гүйцэтгүүлж, холбогдох бичиг баримтын бүрдлийг хангуулан ажиллахыг тус тус даалгасгай.

3. Аймгийн хэмжээнд хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, үр дүнтэй зохион байгуулан, холбогдох хууль тогтоомж, энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, явцын болон гүйцэтгэлийн талаар тухай бүр танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ж.Сайнцог/-д үүрэг болгосгай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ

